



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 4/20

Мандалговь

Зөвлөмж хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүээр зүйлийн 29.1.5"а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолын 5, 7, 11 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан албан даалгавар, зөвлөмж шийдвэрүүдийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг харъяа төсөвт байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.


2.Тус сумын харъяа сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан багш, ажилчдын ажлын цагийг богиносгож, 2020 оны 01 сарын 31-нээс 02 сарын 28-ны өдрийг дуустал өглөө 9.00-13.00 цаг хүртэл буюу өдөрт 4 цаг ажиллуулсугай.

3.Тухайн хугацааны багш, ажилчдын сарын үндсэн цалин бусад нэмэгдлийг хуулийн дагуу тооцож олгохыг байгууллагын ня-бо нарт зөвшөөрсүгэй.

4.Сургалтын үйл ажиллагааг 03 сарын 02-ноос эхлэн Бямба гарагт хичээллэх тул тухайн цагийг богиносгож ажилласан цагтай уялдуулан тооцохыг төсвийн шууд захирагч нарт зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГТОХ



D:/document /Zasag darga/ B.Zahiramj .doc 01.30

4820 130